"НЭГДСЭН ТӨСЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР" ОНӨТҮГ

НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВЭРТ ДҮҮЖИН ЗАМЫН ТЭЭВЭР НЭВТРҮҮЛЭХ ТӨСЛИЙН ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ХЯНАЛТ ТАВИХ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР
№ НТУГ- ДТТ-ЗҮАД -25/01

УЛААНБААТАР ХОТ

БАТЛАВ:

НЭГДСЭН ТӨСЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР ОНӨТҮГ-ЫН ЗАХИРАЛ

Э.ҮҮВШИНЖАРГАЛ

НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВЭРТ ДҮҮЖИН ЗАМЫН ТЭЭВЭР НЭВТРҮҮЛЭХ ТӨСЛИЙН ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ХЯНАЛТ ТАВИХ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

2025.08.07 № НТУГ- ДТТ-ЗҮАД -25/01 Улаанбаатар хот

Нэг. Үндэслэл

1.1. Улсын их хурлын 2020 оны 23 дугаар тогтоол "Монгол Улсыг 2021 – 2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" /9.3.4/, Улсын их хурлын 2020 оны 24 дүгээр тогтоол "Монгол Улсын Засгийн газрын 2020 – 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр", Улсын их хурлын 2020 оны 52 дугаар тогтоол "Алсын хараа-2050", Улсын их хурлын 2021 оны 106 дугаар тогтоол "Шинэ сэргэлтийн бодлого" /4.1/, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хооронд 2020 оны 5 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан Санхүүгийн хэлэлцээр, Санхүүгийн хэлэлцээр соёрхон батлах тухай Монгол Улсын 2020 оны хууль, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 02/10 дугаар тогтоол "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020 – 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр" /6.3.15.2/, Захиалагч болон Гүйцэтгэгч нарын хооронд 2023.06.16-нд байгуулсан барилга угсралтын ЕРС гэрээ, Нийслэлийн засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 30 ны өдрийн А/769 дугаар захирамж.

Хоёр. Зорилго

2.1. Төслөөр хийгдэх барилга угсралтын ажил, тоног төхөөрөмжийн угсралт, инженерийн шугам сүлжээний ажил, гадна тохижилтын ажил, туршилт тохируулгын ажилд тавих техник, технологийн хяналтыг олон улсын жишгээр гүйцэтгэх

2.2. Дүүжин замын тээвэр төслийн барилга угсралтын ажлын чанарыг Монгол Улс, олон улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм стандартад нийцүүлэн ажиллах.

2.3. Нийслэл Улаанбаатар хотын авто замын ачааллыг бууруулах зорилгын хүрээнд төслийн зөвлөх үйлчилгээний мэргэжлийн баг ажиллуулж төлөвлөлт хийлгэж, зөвлөмж, дүгнэлт, тайлан гаргуулах

Гурав. Нэр томъё

3.1 Захиалагч- Нийслэлийн засаг даргын тамгын газар ,түүний итгэмжлэгдсэн төлөөлөх Аж ахуйн нэгж буюу хуулийн этгээд

3.2 Гүйцэтгэгч- Нийслэл хотод дүүжин замын тээвэр нэвтрүүлэх төслийн барилга угсралт, тоног төхөөрөмж угсралт, зураг төсөл боловсруулах ажлуудыг гүйцэтгэгч ба түүний туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж буюу хуулийн этгээдүүд хамаарна.

3.3 Зөвлөх- Энэхүү ажлын даалгаварт тусгагдсан зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж буюу хуулийн этгээд

3.4 Төсөл- Нийслэл хотод дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл

3.5 Ерөнхий гүйцэтгэгч- Захиалагчтай гэрээ байгуулсан гадаад болон дотоодын аж ахуйн нэгж буюу хуулийн этгээд

3.6 Туслан гүйцэтгэгч- Ерөнхий гүйцэтгэгчтэй гэрээгээр холбогдсон бүх төрлийн аж ахуйн нэгж, хуулийн этгээдүүд хамаарна.

Дөрөв. Хүрэх үр дүн

4.1 Төслийн хүрээнд хийгдэх дүүжин замын тээврийн байгууламж, барилга угсралт, тоног төхөөрөмжийн угсралт, инженерийн шугам сүлжээний угсралтын ажлын явцад өдөр тутмын техникийн хяналт хийх Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэж, ажлын уялдааг хангах, чанар стандартыг мөрдүүлэх.

4.2 Нийслэл хотод авто замын түгжрэлийг бууруулах хүрээнд олон төрөлт нийтийн тээврийн сүлжээг нэмэгдүүлэх болон бусад төсөл, арга хэмжээтэй уялдуулж төслийг зохион байгуулан ашиглалтад оруулах.

4.3 Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд хэрэгжихээр төлөвлөгдсөн "Улаанбаатар метро" төсөл, "Тулгуурт байгууламж бүхий хөнгөн галт тэрэг нэвтрүүлэх" төсөл, "Улаанбаатар хотын Тогтвортой авто зам, тээвэр" төсөл болон бусад төсөл, арга хэмжээнүүдтэй уялдуулж ажиллах, холбогдох мэдээллээр хангаж дэмжлэг үзүүлэх

4.4 Нийслэл хотод олон улсын чанар, стандартыг хангасан дүүжин замын нийтийн тээврийн хэрэгсэлтэй болох.

Тав. Зөвлөх үйлчилгээний хамрах хүрээ

5.1 Зөвлөх үйлчилгээний "Улаанбаатар хотод дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл" дэх үйл ажиллагааны хамрах хүрээ нь:

5.1.1 Барилга угсралтын ажлын техникийн байнгын хяналт.

5.1.2 Технологийн дагуу хийж буй эсэхийг хянах баталгаажуулалт хийлгэх.

5.1.3 Материалын чанар, тоног төхөөрөмжийн стандартыг шалгах, хангуулах баталгаажуулалт хийх, хийлгэх.

5.1.4 Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу ажил, үйлчилгээ явагдаж буй эсэхэд хяналт тавих, төлөвлөгөөний дагуу ажлыг гүйцэтгүүлэх.

5.1.5 Дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх, тайлан гаргаж танилцуулах.

5.1.6 Шалгалт, туршилт хийх, чанарын хяналт хийх, хяналтыг баримтжуулах, баталгаажуулалт хийх.

5.1.7 Техник хэрэгслийн хангалт хийх.

5.1.8 Инженер техникийн ажилтнуудад чадавх бэхжүүлэх мэргэжлийн сургалт зохион байгуулах.

5.1.9 Төсөлтэй холбогдох нэмэлт ажил болон бусад ажлын хяналтыг хийх баримтжуулах, баталгаажуулах.

5.1.10 Төслийг амжилттай хүлээлгэн өгөх

5.2 Зөвлөх үйлчилгээний үргэлжлэх хугацааны хамрах хүрээ нь:

5.2.1 Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан өдрөөс эхэлнэ.

5.2.2 Төслийн баталгаат хугацааг дуусах хүртэл

5.3 Байршлийн хамрах хүрээ нь:

5.3.1 Төсөл хэрэгжиж буй төслийн талбай.

5.3.2 Төслийн түр битүү болон Ил агуулах.

5.3.3 Төслийн хүрээнд хийгдсэн технологийн зам, талбай, гүүрийн байгууламж

ЗУРГАА. Дүүжин замын тээвэр барих төслийн техник, технологийн хяналт хийх

6.1 Гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажлуудыг чанар, стандартын дагуу хүлээн авна.

6.2 Гүйцэтгэгчийн ажлын төлөвлөгөө, ажиллах хүч, тоног төхөөрөмжийн нарийвчилсан төлөвлөгөөг хянаж батлах Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийн байдлыг шалган, зохих тохиргоо зүгшрүүлэлт хийсэн, ажлын шаардлага хангасан эсэхийг баталгаа.

6.3 Гүйцэтгэгчээр ажлын дэлгэрэнгүй болон нэгдсэн график, төлөвлөгөөг гаргуулан хянан баталгаажуулах, Захиалагчид танилцуулах.

6.4 Гүйцэтгэгчийн хяналтын лабораторийн байдлыг шалгах лабораторийн туршилт, шинжилгээний ажилд өдөр тутмын хяналт тавьж, шинжилгээний үр дүнг баталгаажуулж ажиллана.

6.5 Гүйцэтгэгчийн чанарын баталгаат хугацааны төлөвлөгөөг гаргуулж, хяналт тавина.

6.6 Гүйцэтгэгчийн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын төлөвлөгөөг хянан баталгаажуулна.

6.7 Техникийн шаардлагын дагуу тулгуур багана болон буудлуудын суурийн дээд ба доод үе, барилга угсралтанд ашиглагдах материал, элс-хайрган хольц, цемент, буталсан чулуу, ус, арматур, төмөр бетон хоолой болон бусад материалуудын эх үүсвэрийг баталгаажуулж, Захиалагчаас зөвшөөрөл авах.

6.8 Тулгуур багануд болон буудлууд кабины гаражын барилга угсралт, тоног төхөөрөмж угсралт, инженерийн шугам сүлжээний ажил, гадна тохижилтын ажил зэрэгт хяналт тавин тэдгээрийг баталгаажуулах.

6.9 Техникийн шаардлагыг үндэслэн ажил гүйцэтгэх технологийн карт боловсруулах ажилд хяналт тавин дэмжлэг үзүүлж ажиллана.

6.10 Гүйцэтгэгчийн гаргасан ажлын төлөвлөгөө, төлөвлөсөн угсралтын ажил, угсралтын зураг, механикийн, материалын болон геодезийн хэмжилтийн үр дүнг шалган баталгаажуулж, ажил гүйцэтгэх зөвшөөрөл өгөх.

6.11 Гүйцэтгэгчийн гаргасан барилга угсралт болон тоног төхөөрөмж угсралт суурьлуулалтын ажил, технологийн зам барих, түр агуулах барих ажлуудад шаардлагатай төлөвлөгөөг хянаж, батлах.

6.12 Зөвлөх нь дээр заагдсан бүх төрлийн ажил үйлчилгээнд хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, байгаль орчны холбогдох хууль, дүрэм, журмыг стандартын дагуу дагаж мөрдүүлэх, хангуулах ба захиалагчийг хувийн хамгаалах хэрэгслээр хангана.

6.13 Зөвлөх нь ажлын явцад Гүйцэтгэгчийн хийсэн ажлын тоо, хэмжээг геодезийн болон бусад хэмжилтийн багаж ашиглан хяналт хийж, тайлан гаргаж Эрх бүхий этгээдэд ирүүлнэ.

6.14 Дүүжин замын тээврийн барилга болон тулгуур багануудын суурийн доод ба дээд үе, бетон цутгалт, арматур угсралтын ажил болон бусад үе шатны ажлуудын технологийн дараалал, ажлын явцын байдлыг өдөр бүр шалгаж дараагийн үе шатны ажлыг гүйцэтгэх зөвшөөрлийг бичгээр өгч байх.

6.15 Зураг, төсвийн хүрээнд дүүжин замын байгууламж, гадна тохижилт, инженерийн шугам сүлжээний ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулах.

6.16 Дүүжин замын тээвэртэй холбоотой бүх төрлийн зөвшөөрлийг холбогдох эрх бүхий байгууллагаас авахад гүйцэтгэгчид дэмжлэг үзүүлнэ.

6.17 Кабин, ган татлага болон бусад тоноглолыг суулгахаас өмнө зураг, төсөв, гүйцэтгэлийг техникийн шаардлагын дагуу урьдчилан хянаж батлах.

6.18 Ажил эхлэхээс өмнө ган бүтээцийн шинжилгээ болон цемент бетоны орц тогтоож баталгаажуулах, бусад материалыг итгэмжлэгдсэн лабораториор баталгаажуулна.

6.19 Ган бүтээц болон бетон хольцын орц ба чанарт техникийн шаардлагын дагуу өдөр тутмын хяналт тавина.

6.20 Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж, ажил, ажиллах хүчний даатгалын гэрээг хянах.

6.21 Ерөнхий болон туслан гүйцэтгэгч байгууллага нь батлагдсан ажлын зураг, техникийн шаардлагын дагуу зөвшөөрөгдсөн материал, тоног төхөөрөмж ашиглан ажил гүйцэтгэх технологийн дагуу барилга угсралтын ажлыг явуулж байгаа эсэхэд Зөвлөх өдөр тутмын хяналтыг хийж тэмдэглэл хөтөлнө.

6.22 Ерөнхий болон туслан гүйцэтгэгчийн өдөр тутмын тайлангийн гүйцэтгэлд хяналт тавих, тайланг нэгтгэн ирүүлнэ. Өдөр тутмын тайлан PMIS системд үнэн зөв, бүрэн гүйцэт оруулж буй эсэхэд хяналт тавина.

6.23 Ерөнхий гүйцэтгэгчээс илгээсэн тоног төхөөрөмжүүдийг хүлээн авах, ган бүтээц болон тоног төхөөрөмжийн хийцийн эд ангиудыг бат бэхийн туршилт болон материалын шинжилгээнд итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэх баталгаажуулалт хийлгэх ажлыг хариуцан зохион байгуулж ажиллана.

6.24 Гүйцэтгэгчийн ажлын зураг, материал, хийц, бүтээц, тоног төхөөрөмж, ажлын аргачлал өөрчлөгдөх бүрд зөвлөх тэдгээрийг хянан баталгаажуулж захиалагч болон холбогдох байгууллагатай зөвшилцөж зөвшөөрөл олгоно.

6.25 Батлагдсан зураг төсөл болон нэмэлтээр хийгдэх зураг төсөлд оновчтой шийдэл санал болгож сайжруулалт хийх болон гүйцэтгэлийн зургийг хянан баталгаажуулах, саналаа захиалагчид өгөх.

6.26 Ажлын бус амралтын өдөр буюу илүү цагаар гүйцэтгэгч ажиллах шаардлага үүсэж хүсэлт гаргавал зөвлөх ажиллах үүрэгтэй ба илүү цагаар ажилласан хөлсийг захиалагч хариуцахгүй болно.

6.27 Ерөнхий болон туслан гүйцэтгэгчийн ирүүлсэн **ажлын баталгаажуулалтын хүсэлт (WIR)** болон **материалын баталгаажуулалтын хүсэлт (MIR)**-ийг шалган баталгаажуулах, ажлын гүйцэтгэл, ашигласан материал нь зураг төсөл, техникийн тодорхойлолт болон стандартын шаардлагад нийцэж буй эсэхийг шалгана. Хэрэв гүйцэтгэл болон материал нь **шаардлага хангахгүй** бол **шаардлага хангаагүй тухай албан ёсны тэмдэглэл (Non-Conformance Report, NCR)** үйлдэж, гүйцэтгэгчид **засварлах, дахин хийх, эсвэл орлуулах** талаар **зөвлөмж, чиглэл өгнө.** Засвар, дахин гүйцэтгэл хийгдсэний дараа тухайн ажлыг дахин шалгаж баталгаажуулна.

6.28 **Төслийн ажил гүйцэтгэх аргачлал (Method Statement) болон шалгалт, туршилтын төлөвлөгөө (Inspection and Test Plan, ITP)**-г баталгаажуулан, батлагдсан баримт бичгүүдийн дагуу ерөнхий болон туслан гүйцэтгэгчийн ажлыг хянаж ажиллана. Хэрэв ерөнхий болон туслан гүйцэтгэгч нь батлагдсан аргачлал, ITP-д заасан шаардлагын дагуу ажил гүйцэтгээгүй тохиолдолд тухайн ажлыг **зөвшөөрөхгүй бөгөөд дахин хийлгүүлэх, засварлуулах арга хэмжээ авхуулна.** Ажлын дахин гүйцэтгэл нь шаардлагад **нийцсэн гэж нотлогдох хүртэл** хяналт, баталгаажуулалтыг үргэлжлүүлнэ.

6.29 Зөвлөх үйлчилгээний хүрээнд чанарын хяналт, баталгаажуулалт хийх, үйл ажиллагааны төлөвлөгөө, журам боловсруулан гаргана.

Долоо. Тусгай шаардлага:

7.1 Инженер техникийн ажилчдын мэргэжил дээшлүүлэх, чадавхжуулах сургалт зохион байгуулах:

7.1.1 Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотойгоор дүүжин замын тээврийн угсралт, ашиглалт, засвар үйлчилгээ, чиглэлээр нийслэлийн холбогдох байгууллагуудын инженер техникийн ажилчдыг мэргэжил дээшлүүлэх, чадавхжуулах, гадаад орны туршлага судлах богино (5-7 хоног), дунд (10-14 хоног) хугацааны сургалт зохион байгуулна.

7.1.2 Сургалтын хөтөлбөрийг Захиалагч байгууллага батлах бөгөөд гадаад, дотоод гэсэн 2 хэлбэртэй явагдана.

7.1.3 Сургалтад хамрагдах хүний тоо 20 хүнээс багагүй байна.

7.2 Төсөл арга хэмжээнд зориулж автомашин, тоног төхөөрөмж зэрэг техникийн туслалцаа үзүүлэх:

7.2.1 Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой зайлшгүй шаардагдах машин, тоног төхөөрөмжийг ажиллуулах шаардлагатай. Гэрээгээр ажил эхэлж дуусах хүртэл техник, тоног төхөөрөмжөөр захиалагчийг хангаж, техникийн туслалцаа үзүүлнэ.

- Ажлын зориулалттай туулах чадвартай автомашин
- Өндөр хүчин чадал бүхий компьютер - 2ш
- Төслийн талбайд байршуулах зөвлөхийн багийн түр ажлын байртай байх

7.3 Дүүжин замын тээвэр нэвтрүүлэх төслийн хүрээнд:

7.3.1 Монгол Улсын стандарт, норм норматив, дүрмийн дагуу суурийн болон бусад гүйцэтгэсэн ажлуудыг холбогдох үзлэг шалгалтыг хийж бичиг баримтын дагуу дүйцүүлэн тооцож хүлээн авах.

7.3.2 Барилгын болон тоног төхөөрөмж угсралтын ажлын явцад ажлын зураг, техникийн шаардлага зөрчих, батлагдаагүй материал, тоног төхөөрөмж ашиглах, батлагдсан аргачлалыг зөрчиж ажил гүйцэтгэсэн тохиолдолд Зөвлөх нь Гүйцэтгэгчийн ажлыг зогсоох үүрэгтэй бөгөөд ажил зогсоох шаардлагыг бичгээр өгнө.

7.3.3 Зөвлөх нь долоо хоног, сарын эхээр Гүйцэтгэгчийг урин талбайн уулзалт хийх бөгөөд (Захиалагчийн төлөөллийг байлцуулах) энэ уулзалтаар долоо хоногт болон сард төлөвлөсөн ажлын явц, гүйцэтгэл, ажлын чанар, ажлын графикийн өөрчлөлт зэрэг барилга угсралт, тоног төхөөрөмж угсралтын ажлын явцтай холбоотой асуудлуудыг хэлэлцэх ба уулзалт бүрийн тэмдэглэлийг хөтөлж баталгаажуулна. Онцгой нөхцөл байдал үүссэн тухай бүрд уулзалт зохион байгуулж болно.

7.3.4 Зөвлөх нь захиалагчаар дамжуулан холбогдох байгууллагуудтай албан бичгээр аливаа асуудлыг шийдвэрлэж байна.

7.3.5 Гүйцэтгэгчийн хийсэн ажил нь чанарын шаардлага хангаагүй бол түүнийг дахин хийлгэх, засварлуулах зэрэг арга хэмжээг тухай бүрд авах бөгөөд тус ажилтай холбоотой нэмэлт төлбөр хийгдэхгүй.

7.3.6 Зөвлөх нь зураг төсөл, барилга, байгууламжийн аливаа ажлын өөрчлөлт гарахаар бол гэрээнд заасан захиран зарцуулах боломжит өртгөөс давсан бол өөрчлөлтийн хүсэлтийн маягтыг бөглөж, холбогдох материалуудыг хавсарган захиалагчид танилцуулах үүрэгтэй бөгөөд Барилгын тухай хуулийн болон гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу Зөвлөх нь шийдвэр гаргах эрхтэй. Зөвлөх инженерийн эрх, үүргийн тухай зөвлөхийн гэрээнд нарийн тусгаж өгнө.

7.3.7 Зөвлөх нь барилгын ажлын явцын тайланг долоо хоног, сар, хагас жил тутамд боловсруулж захиалагч талын баталгаажуулсан тайлангийн загвараар гарган захиалагчид ирүүлэх үүргийг хүлээнэ. Тайланд ажлын явц, ажлын явцад гарсан аливаа өөрчлөлтийн асуудал, цаашид авах арга хэмжээний талаар холбогдох фото зураг, график, тооцооны хамт танилцуулж байна. Барилгын ажил дууссаны дараа Зөвлөх нь төгсгөлийн тайлан бичиж захиалагчид хүргүүлнэ.

7.3.8 Гүйцэтгэгч гэрээний заалтуудыг зөрчиж, гэрээт хугацаандаа ажлаа дуусгаагүй бол Зөвлөх нь гэрээний зохих заалтын дагуу гэрээний торгууль

ногдуулах санал гаргаж захиалагчид танилцуулах үүрэгтэй бөгөөд торгууль ногдуулах асуудлыг захиалагч шийдвэрлэн Зөвлөхөд мэдэгдэнэ.

7.3.9 Гүйцэтгэгч гэрээт хугацаандаа ажлаа дуусгаж чадахгүй, ажлыг чанартай хийж гүйцэтгэх чадваргүй зэрэг асуудал тодорхой болсон нөхцөлд Зөвлөх нь гүйцэтгэгчийн гэрээг цуцлан өөр Гүйцэтгэгч сонгох, туслан гүйцэтгэгч авах зэрэг саналаа Захиалагчид танилцуулна. Гэрээ цуцлах, өөр гүйцэтгэгч сонгох, туслан гүйцэтгэгч нэмж авах асуудлыг Захиалагч тал шийдвэрлэнэ.

7.3.10 Гүйцэтгэгч ажлаа дуусган барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссоор ажлаа хүлээлгэж өгсний дараа Зөвлөх нь барилгын ажил дууссан тухай тайлан бичиж, захиалагчид хүргүүлнэ.

7.3.11 Гүйцэтгэгчийн гэрээнд заасан баталгаат хугацаа дууссаны дараа Зөвлөх нь дүүжин замын тээврийн ашиглалтын байдлыг хянан үзэж, ажлын чанар муугаас болж гарсан эвдрэлийг Гүйцэтгэгчээр засуулан эцсийн тайлан бичиж барьцааны болон буцаах мөнгийг Гүйцэтгэгч байгууллагад эргүүлэн төлөх хүсэлтийг захиалагч талд гаргана.

7.3.12 Баталгаат хугацааны турш Зөвлөх нь жилд 4-өөс цөөнгүй удаа барилгын ашиглалтын байдалд үзлэг хийх бөгөөд хугацаа дуусах үед барилгын байдал болон Гүйцэтгэгчийн хийх шаардлагатай засварын ажлын талаар Захиалагчид танилцуулна.

7.3.13 Ажил дууссаны дараа дүүжин замын тээврийг хүлээж авахад захиалагч болон гүйцэтгэгч талуудад дэмжлэг үзүүлнэ.

7.3.14 Эдгээр үйл ажиллагааны дараа төслийн эцсийн тайлан бичиж захиалагчид хүлээлгэн өгснөөр барилгын ажилд хяналт тавих зөвлөх үйлчилгээ дуусгавар болно.

7.3.15 Зөвлөх нь захиалагчтай гэрээний болон чанарын баталгаат хугацааны турш байнгын харилцаатай байж бүх талын мэдээллээр хангана. Зөвлөх нь захиалагч тал болон Гүйцэтгэгч талтай монгол хэл дээр харилцах бөгөөд бүх тайлан, төлөвлөгөө материалыг монгол, англи хэл дээр бэлтгэн танилцуулна. Тайланг гэрээнд заасан хугацаанд нь боловсруулж гаргах ба эцсийн тайланг холбогдох засвар өөрчлөлтийг тусган эцсийн шатны тайлан, бүтээгдэхүүнийг (хэвлэмэл, pdf, docx, xlsx, dwg) боловсруулна.

Найм. Зөвлөх үйлчилгээний Гүйцэтгэгчид тавигдах шаардлага

8.1 Зөвлөх үйлчилгээний Гүйцэтгэгч байгууллага нь онцгой төвөгшил бүхий гүүрэн байгууламжийн барилгын салбарт үйл ажиллагаа явуулдаг, зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий Монгол улсын эсвэл гадаад улсын хуулийн этгээд байна.

8.2 Барилга угсралт, тоног төхөөрөмжийн угсралтын ажилд техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлсэн туршлагатай байх. (Гадаадын ижил төрлийн төсөлд эсвэл гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдэд техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан бол давуу тал болно.)

8.3 Зөвлөх үйлчилгээний байгууллага нь Улаанбаатар хотод дүүжин замын тээвэр нэвтрүүлэх төслийн ажилд хяналт тавих, төлөвлөлт хийх, дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх багийг ажиллуулах бөгөөд шаардлагатай голлох мэргэжилтнүүдтэй байна. Гүйцэтгэгчийн ажлын зохион байгуулалт, онцлогоос шалтгаалан шаардлагатай үед голлох мэргэжилтнүүдийг нэмэгдүүлэн ээлжийн хуваарьт оруулан ажиллуулна.

8.4 Зөвлөх үйлчилгээний багийн ажлын байр нь төслийн талбайд байршина.

8.5 **Зөвлөхийн хяналтын багийн гишүүдэд тавигдах шаардлага**

№	Албан тушаал	Тавигдах шаардлага	Хүний тоо	Хүн/сар
1	Хяналтын багийн ахлагч	Гадаад, дотоодын томоохон төсөл арга хэмжээнүүдэд 15-аас доошгүй жил ажилласан, барилга, дэд бүтцийн угсралтын ажлын хяналтад ажиллаж байсан туршлагатай, зөвлөх инженер байх.	1	11
2	Барилгын инженер	Барилгын инженер чиглэлээр 5-аас доошгүй жил, үүнээс 3-аас доошгүй жил барилгын хийц бүтээцлэлийн хяналтад ажилласан туршлагатай, мэргэшсэн зэрэгтэй байх.	1	11
3	Материалын инженер	Материал судлал, металлурги чиглэлээр 5-аас доошгүй жил, үүнээс 3-аас доошгүй жил барилгын чанарын хяналтаар ажилласан туршлагатай байх. Материалын тооцоолол хийх , тоо хэмжээ, чанарыг шалгах нягтлах чадвартай, Барилгын материалын үйлдвэрлэлийн технологи мэргэжилтэй байх.	1	11
4	Механикийн инженер	Суурин тоног төхөөрөмж, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн чиглэлээр 5-аас доошгүй жил, үүнээс 3-аас доошгүй жил гүүрийн барилгын хяналтаар ажилласан, хяналтын ажлын туршлагатай, механикийн тооцоо хийх чадвартай ,механик инженер, мэргэшсэн зэрэгтэй байх.	1	11

5	Барилгын Чанарын хяналтын инженер	Барилгын инженерийн чиглэлээр 5-с дээш жил ажилласан бөгөөд үүнээс 3-с доошгүй жил чанарын хяналтаар ажилласан туршлагатай ба барилгын инженерийн мэргэжилтэй байх. Барилгын стандарт, дүрэм журмыг мэддэг байх Төсөлд хэрэглэгдэх материал, тоног төхөөрөмжийн болон ажил үйлчилгээний чанарын хяналтыг хийж гүйцэтгэх ба барилгын ажлын явцыг хянах, үнэлгээ өгөх чадвартай байх	1	11
6	Хэмжилтийн Инженер (геодезийн инженер)	Тухайн чиглэлээр 5 жил, үүнээс 3-аас доошгүй жил авто замын барилгын хяналтад ажилласан, хяналтын ажлын туршлагатай, геодезийн инженерийн мэргэжилтэй, мэргэшсэн зэрэгтэй байх.	1	11
7	ХАБЭА ажилтан	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр 5-аас доошгүй жил, үүнээс 3-аас доошгүй жил хяналтаар ажилласан ба олон улсын ХАБЭА-н ISO:45001 стандартыг хангаж ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.	1	11
8	Авто замын инженер	Зам барилгын чиглэлээр 5-аас доошгүй жил, үүнээс 3-аас доошгүй жил авто замын барилгын хяналтад ажилласан, зургийн дагуу тоо хэмжээг бодож шалгах нягтлах чадвартай, авто замын инженерийн мэргэжилтэй, мэргэшсэн зэрэгтэй байх.	1	5
9	Байгаль орчны хяналт үнэлгээний мэргэжилтэн	Байгаль ашиглалт, хяналт, үнэлгээний чиглэлийн мэргэжлийн бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх /Гэрээт байж болно/	1	5
10	Цахилгаан холбоо дохиоллын инженер	Цахилгаан, холбоо дохиоллын чиглэлээр 10-оос доошгүй жил, үүнээс 3-аас доошгүй жил хяналтаар ажилласан, мэргэжлийн дагуу зураг төсөл болон барилгын цахилгаан, холбоо дохиоллын ажил гүйцэтгэж байсан туршлагатай, мэргэшсэн зэрэгтэй байх.	1	11
11	Инженерийн шугам сүлжээ хариуцсан инженер	Дулаан, цэвэр, эсвэл бохир ус (гидрологи) чиглэлээр 10-оос доошгүй жил, үүнээс 3-аас доошгүй жил хяналтаар ажилласан, мэргэжлийн дагуу зураг төсөл болон барилгын ажил гүйцэтгэж байсан туршлагатай, мэргэшсэн зэрэгтэй байх.	1	11

12	Орчуулагч	Техник тоног төхөөрөмжийн чиглэлээр орчуулагчаар ажиллаж байсан туршлагатай. Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан. Англи хэлний орчуулагч байх. /Гэрээт байж болно/	1	11
13	Гүүр, туннелийн инженер	Гүүрийн байгууламжийн төсөл дээр мэргэжилээрээ 5-аас доошгүй жил ажилласан, үүнээс 3-аас доошгүй жил нь хяналтын ажлын туршлагатай Гүүр, туннелийн инженерийн баклавр ба түүнээс дээш зэрэгтэй байх /Гэрээт байж болно/	1	5
14	Баримт бичгийн хяналтын ажилтан	Баримт бичгийн хяналтын чиглэлээр ажиллаж байсан туршлагатай. Мэргэжлээрээ 8-аас доошгүй жил ажилласан. Англи хэлтэй байх	1	11
15	Жолооч	Жолооны B,C,D ангилалтай мэргэшсэн жолооч. Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай.	1	11
		нийт	**15**	**147**

8.6 Дээрх хүснэгтэд 9.2 д заагдсан ажлуудын хүн/сарыг нэмж тооцно.

8.7 Зөвлөх үйлчилгээний хяналтын багийн ажлын болон ажилтнуудын амьдрах байр, тэдгээрийн тавилга, хэрэгсэл, компьютер болон албан өрөөний бусад тоног төхөөрөмж, талбайд болон төвтэйгөө шуурхай холбоо барих хэрэгсэл, геодезийн багаж, лабораторийн шинжилгээгээр баталгаажуулах, ажлын хээрийн хувцсаар хангагдсан байх ба тээвэр, холбоо, цахилгаан дулаан, бичиг хэрэг болон бусад бүх зардлыг Зөвлөх өөрөө хариуцах болно.

Ес. Төсөл хэрэгжих хугацаа

9.1 Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу барилгын ажил эхлэх өдрөөс зөвлөх үйлчилгээний ажил эхэлж барилгын ажлын баталгаат хугацаагаар дуусгавар болно. Захиалагч болон Зөвлөх үйлчилгээ Гүйцэтгэгчийн хооронд байгуулах гэрээнд хугацааг тодорхой тусгах бөгөөд гэрээнд заасан төлбөрт багтаан зөвлөх үйлчилгээг үзүүлнэ.

9.2 Зөвлөхийн баг нь барилгын ажлын хугацаанд үе шатны техник, технологийн хяналтын үүргийг гүйцэтгэх бөгөөд төслийн хүрээнд хэрэгжүүлсэн барилга, байгууламжийг ашиглалтад орсон хугацаанаас хойш чанарын баталгаат хугацаанд улирал тутамд үзлэг шалгалт хийж холбогдох тайланг захиалагч байгууллагад ирүүлнэ.

9.3 Зөвлөхийн баг нь төслийн талбайд байрлан, өдөр тутмын хяналтыг тавьж ажиллана.

Арав. Санхүүжилтийн задаргаа, төлбөрийн хуваарь

№	Зардал	Бүрдэл	Нийт санхүүжилтэд эзлэх хувь
1	Ажиллах хүчний зардал	- Цалин, хөлс, татвар	**65%**
2	Үйл ажиллагааны зардал	- Машин механизм, техникийн туслалцааны зардал - Үйл ажиллагааны зардал	**12%**
3	Сургалт зохион байгуулах зардал	- Богино болон дунд хугацааны сургалтууд	**8%**
4	Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татвар хураамж	- Магадалшгүй ажил - Нэмэгдсэн өртгийн албан татвар - Бусад	**15%**
		Нийт	**100%**

Дээрх **санхүүжилтийн задаргаа, төлбөрийн хуваарь** нь урьдчилсан байдлаар бөгөөд **Нийт санхүүжилтэд эзлэх хувь** нь өөрчлөгдөж болно.

Танилцсан:

Төслийн удирдлагын албаны дарга /Б.Мөнхбаатар/

Төслийн менежер (захирал): / Б.Дамбарагчаа/

Боловсруулсан:

Ахлах инженер /Г.Түвшинсанаа/

Механик инженер /Б.Маргад/